



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 01

Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хурлын 01 дүгээр тэмдэглэлд:

“Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, Эрчим хүчний сайдын 2023 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн а/20 дугаар тушаал, 2023 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн а/46 тоот албан бичгээр ирүүлсэн удирдамжийн дагуу компанийн 2023 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Хангамж, үйлчилгээний хэлтсийн дарга А.Төгсмандах танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1. Компанийн 2023 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ТУЗ-ын гишүүд хэлэлцэн дэмжив;
2. Компанийн 2023 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг холбогдох хууль, журмын дагуу баталж, цахим системээр Эрчим хүчний яам, Сангийн яамаар тус тус батлуулах, хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажиллахыг гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт үүрэг болгов;
3. Компанийн 2023 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг Шилэн дансны цахим системд хуулийн хугацаанд байршуулах, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, биелэлтийг хагас, бүтэн жилээр Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт даалгав” гэжээ.

ДАРГА

Ж.ЖАНАРБААТАР



580020018